



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 8/29

Хэрлэн сум

Д.Өнөрцэцэгийг ажилд томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.1, 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн Дангаасүрэнгийн Өнөрцэцэгийг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан тушаалд 2022 оны 4 дүгээр сарын 11-ээс эхлэн томилсугай.

2.Д.Өнөрцэцэгийн үндсэн цалинг ТЗ-10-3 шатлалаар тогтоон үндсэн цалин 981742 (есөн зуун наян нэгэн мянга долоон зуун дөчин хоёр мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 15, зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Өнөрцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030701